



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Түр журам, заавар батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.5, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг нэгдүгээр, "Гэр (амрах байр)-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ыг хоёрдугаар, "Коронавируст халдвар /КОВИД-19/ илэрсэн объектыг хамгаалах түр журам"-ыг гуравдугаар, "Голомтот бүс нутгаас агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхэд баримтлах халдвараас сэргийлэх түр заавар"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд /С.Энхболд/, Гадаад харилцааны сайд /Б.Батцэцэг/, Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга /Т.Гантулга/ нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан түр журам, зааврыг хэрэгжүүлж ажиллахыг Улсын онцгой комиссын Шуурхай штаб, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга /бригадын генерал Г.Ариунбуян/-д даалгасугай.


5. Түр журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын "Түр журам батлах тухай" 2020 оны 155 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

Улсын онцгой комиссын даргын
2021 оны 02 дугаар сарын 25 -ны өдрийн
02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТУСГААРЛАН АЖИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам /цаашид "журам" гэх/-аар коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед гадаад улсаас ирсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тусгаарлан ажиглах байранд оролцогч талуудын халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх, тэдгээрийн үүрэг хариуцлага, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.3. "Тусгаарлан ажиглах" гэж гадаад улсаас ирсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг урьдчилан тусгай шаардлагын дагуу бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хяналтад байлгахыг хэлнэ.

1.4. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг улсын хэмжээнд Улсын онцгой комиссын Шуурхай штаб /цаашид "УОКШШ" гэх/, орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын Шуурхай штаб /цаашид "АНСДШШ" гэх/ нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

1.5. Хүнийг тусгаарлан ажиглах үед дараах зарчмыг баримтална:

- 1.5.1. Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;
- 1.5.2. Хууль дээдлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх;
- 1.5.3. Шуурхай, ил тод, нээлттэй байх;
- 1.5.4. Хувь хүний нууцыг чанд хадгалах;
- 1.5.5. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах;
- 1.5.6. Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;
- 1.5.7. Иргэний нөхцөл байдлын мэдээлэл авах эрхийг хангах;
- 1.5.8. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.5.9. Тусгаарлан ажиглах байрны нэг өрөөнд нэг хүн, нэг гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтран амьдрагчийг хамтад нь байрлуулах;

1.6. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааны баримт бичгийг хуулийн этгээд бусдад шилжүүлэх, дамжуулахдаа цахим гарын үсэг хэрэглэнэ.

1.7. "Сэжигтэй тохиолдол" гэж коронавируст халдварын эмнэл зүйн болон тархвар судлалын шалгуур үзүүлэлтээр шинж тэмдэг илэрсэн иргэнийг хэлнэ.

Хоёр. Тусгаарлан ажиглалтын хугацаа, зохион байгуулалт

2.1. Тусгаарлан ажиглах хугацааг дараах байдлаар тогтооно:

2.1.1. Гадаад улсаас ирж байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдаагүй, бүрэн тун хийлгээгүй иргэнийг тусгаарлан ажиглах байранд 10 хоног;

2.1.2. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлыг тусгаарлан ажиглах байранд 7 хоног;

2.1.3. Иргэний тусгаарлан ажиглах байр, гэрийн тусгаарлалтад байх нийт хугацаа хуанлийн 14 хоног байна.

2.4. Нийслэлд тухайн объектод сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтлын эхний PCR шинжилгээг ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг хийж, батлагдсан тохиолдлыг ХӨСҮТ, ЦТЭ, ЭНЭҮТ-2 зэрэг урьдчилан бэлтгэсэн эмнэлэг, ойрын хавьтлыг тусгаарлан ажиглах байр руу шилжүүлнэ. Сэжигтэй тохиолдлыг шинжилгээний хариу гарах хүртэл гэрийн ажиглалтад шилжүүлнэ.

2.5. Батлагдсан тохиолдлыг ХӨСҮТ-ийн Шуурхай хариу арга хэмжээний баг тээвэрлэнэ.

2.6. Ойрын хавьтлыг харьяа дүүргийн шуурхай хариу арга хэмжээний баг тусгаарлан ажиглах байранд тээвэрлэж хүргэнэ. Хяналтын шинжилгээг дүүргийн шуурхай хариу арга хэмжээний баг авч, лабораторид хүргэнэ.

2.7. Сэжигтэй тохиолдлоор бүртгэгдсэн иргэн өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй үед харьяа дүүргийн шуурхай хариу арга хэмжээний баг гэрийн ажиглалтад тээвэрлэж хүргэнэ.

2.8. Тусгаарлан ажиглах байранд эрүүл мэндийн, онцгой байдлын, цагдаагийн алба хаагч, зохион байгуулагч, үйлчилгээний ажилчид үүрэг гүйцэтгэнэ.

2.9. Тусгаарлан ажиглах байранд ажилласан төрийн албан хаагч, тусгаарлах байрны ажилчид үүрэг гүйцэтгэсний дараа "ПГУ"-ийн шинжилгээ өгнө. "ПГУ"-ийн шинжилгээний "сөрөг" хариу гарсны дараа гэрийн ажиглалтад шилжинэ.

2.10. "ПГУ"-ийн шинжилгээг нийслэлд ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг, орон нутагт харьяа Эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна.

2.11. Тусгаарлан ажиглах байрыг сонгох ажлын хэсгийг нийслэлд Улсын онцгой комиссын даргын тушаалаар, орон нутагт аймгийн Онцгой комиссын даргын тушаалаар томилно.

2.12. Хуулийн этгээд, аж ахуйн нэгж нь энэ журмын 3.1-т заагдсан объектыг тусгаарлан ажиглах байрын зориулалтаар ашиглуулах хүсэлтээ ажлын хэсэгт гаргана. Ажлын хэсэг нь уг хүсэлтийг судлан үзэж, энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн объектыг тусгаарлан ажиглах байраар сонгоно.

2.13. Сонгогдсон объектын дүгнэлт, дэлгэрэнгүй мэдээллийг ажлын хэсгээс УОКШШ, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлнэ.

2.14. Тусгаарлан ажиглах байрны эзэмшигчтэй байгуулах гэрээний загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага боловсруулж, санхүүгийн төлбөр тооцооны гүйцэтгэлд хяналт тавина.

2.15. Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэн, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагч, ажилтнаас эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн, эсвэл "аэрэг" гарсан тохиолдолд тусгаарлан ажиглах байрнаас бусад хүнийг гаргах шийдвэр Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс тандалт хийж дуустал хүлээгдэнэ. Тандалт судалгааг боломжит богино хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Тусгаарлан ажиглах байр, түүнд тавигдах шаардлага

3.1. Тусгаарлан ажиглах байрыг дараахи эрэмбээр сонгоно:

3.1.1. зочид буудал

3.1.2. амралтын газар, сувилал

3.1.3. их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, спорт цогцолбор, заал

3.1.4. ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр

3.1.5. эмнэлэг

3.1.6. гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын байр

3.2. Тусгаарлан ажиглах байр нь цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон, галын аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан байна.

3.3. Энэ журмын 7.2-т заасан "цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон" гэсэн нөхцөл, шаардлага сум, тосгонд хамаарахгүй байж болно.

3.4. Тусгаарлан ажиглах байрны ундны усны хэсгийн систем, ундны усны эх үүсвэр, хэрэглээний шугамын усанд мэргэжлийн хяналтын байгууллагаар нян судлалын шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

3.5. Хэсгийн усан хангамжтай тусгаарлан ажиглах байрны усны эх үүсвэр, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх санд холбогдох журмын дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг авч, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангана.

3.6. Зөөврийн усан хангамжтай тусгаарлан ажиглах байрны эх үүсвэрийн ус нөөцлөх савыг 3 сар тутам, ус зөөвөрлөх хадгалах савыг долоо хоногт 2-оос доошгүй удаа угааж цэвэрлэн, халдваргүйжүүлнэ.

3.7. Тусгаарлан ажиглах байрны цонхны салхивчийг нээх боломжтой, эсвэл агааржуулалтын системтэй, насанд хүрээгүй иргэний аюулгүй байдлыг хангасан байна.

3.8. Тусгаарлан ажиглах байрны өрөө тус бүр бие засах, гар угаах нөхцөлөөр хангагдсан ариун цэврийн өрөөтэй, нэг өрөөнд энэ журамд заасан нөхцөлөөр иргэнийг хамт тусгаарласан тохиолдолд ор хоорондын зайг нэг метрээс доошгүй байхаар байрлуулна.

3.9. Тусгаарлан ажиглах байранд эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчийн байрлах өрөө нь гар угаах, усанд орох, бие засах нөхцөлөөр хангагдсан эсвэл гар угаах, усанд орох хэсэг нь ажиглалтад байгаа иргэнээс тусдаа байхаар зохион байгуулна.

3.10. Тусгаарлагдаж байгаа иргэн, үүрэг гүйцэтгэж буй ажилтныг чанар, эрүүл, аюулгүй байдлын шаардлага хангасан хоол, хүнсээр хангана.

3.11. Тусгаарлан ажиглах байр нь иргэнийг байршуулах, албан хаагчдын амрах, хоол үйлдвэрлэх, сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, цэвэрлэгээний материал угааж халдваргүйжүүлж, хадгалах өрөө, хамгаалах хувцас өмсөж, тайлах хэсэгтэй байна. Хувцас тайлах хэсэгт толь, хамгаалах хувцас тайлах дарааллыг харуулсан

зурагт хуудас, 50 литрээс дээш хэмжээтэй "Био аюултай" гэсэн тэмдэглэгээтэй шар өнгийн хогийн уут бүхий "хөл ажиллагаа"-тай хогийн сав зэргийг байрлуулна.

3.12. Тусгаарлан ажиглах байрыг халдвартай "улаан", халдварын эрсдэл дунд буюу завсрын "шар", халдваргүй "ногоон" гэсэн гурван бүсээр хуваана.

3.13. Тусгаарлан ажиглах байранд хяналт тавих камер, зарлан мэдээлэх төхөөрөмжийг давхар бүрт бүрэн хянах боломжтойгоор байрлуулж, камерын бичлэг нь тусгаарлалтын нэг ээлжийн бичлэгийг бүрэн хадгалах хүчин чадалтай байна.

3.14. Тусгаарлан ажиглах байрны хяналтын дэлгэцийг тухайн байрны "ногоон бүс"-д байрлуулна.

3.15. Эмч мэргэжилтэн, бусад алба хаагчийн байрлах өрөө, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлах хэсэг, гал тогооноос тусгаарлан ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл зэрэг орох, гарахыг хориглосон хэсэгт нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байхаар анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

3.16. Өрөө бүрт дараах эд зүйлийг урьдчилан бэлтгэн байршуулсан байна: Үүнд:

- ариун цэврийн цаас, гарын болон эдийн саван, аяга, таваг угаагч шингэн, цэвэрлэгээний алчуур (гал тогооны, тоосны, шалны), өрөө, тасалгаа, ариун цэврийн өрөөнд хэрэглэх угаалга, цэвэрлэгээний бодис, хогийн сав, хар, шар өнгийн хогийн уут,

- "Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас", халуун хэмжигч (эмнэлгийн ажилтан халуун хэмжихээр зохицуулсан бол шаардлагагүй), эмч мэргэжилтэнтэй холбоо барих утасны жагсаалт, ажиглалтын үед мөрдөх санамж, гал түймэр болон ослын үед ашиглах аврах гарцын бүдүүвч зураг, хориглох зүйлсийн анхааруулга, цэвэрлэгээний зааварчилгаа, хог гаргах цагийн хуваарь.

- хаалганы гадна талд хоол, эргэлтийн эд зүйлсийг тавих ширээ (сандал, шүүгээ) байрлуулна.

3.17. Аюултай хог хаягдлыг аймаг, нийслэлд холбогдох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага орон нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага байхгүй тохиолдолд тухайн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллага, энгийн хог хаягдлыг тохижилт үйлчилгээний компани устгана.

Дөрөв. Улсын онцгой комиссын Шуурхай штабын эрх, үүрэг

4.1. Нийслэлд тусгаарлан ажиглах байрны бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах ажлыг УОКШШ-ын даргын үүрэг болгосон бүрэлдэхүүн хэрэгжүүлнэ.

4.2. Тусгаарлан ажиглах байранд ажиллах эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын ажилтны мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн, ажиллах хүчний нөөцийг төлөвлөнө.

4.3. Тусгаарлан ажиглах байранд байгаа хүнийг /бага насны хүүхэд, тусгай хоолны дэглэмтэй иргэн/-д олгох хоолны жишиг цэсийг хүний хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын зөвлөмжийн хүрээнд холбогдох дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах бөгөөд тусгаарлан ажиглах байрны менежерт хүргүүлнэ.

4.4. Тусгаарлан ажиглах байрны удирдлага, ажилтан, эрүүл мэндийн, онцгой байдлын, цагдаагийн алба хаагчдад халдварын сэргийлэлт, албан үүрэг, дэг журам

сахиулахтай холбоотой сургалтыг сар бүр зохион байгуулж, ажлын хариуцлагад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулна.

4.5. Гадаад харилцааны яам, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар гадаад улсаас ирэх иргэдийн нэрийн жагсаалтыг урьдчилан авах бөгөөд иргэдэд гар утсандаа гэрийн тусгаарлалтын хугацаанд ашиглах "CLIX GPS" аппликэйшн суулгах талаар урьдчилан мэдэгдэнэ.

4.6. Авто болон төмөр замын боомтоор татан авах иргэдийн нэрийн жагсаалтыг Монгол Улсаас Оросын Холбооны Улс /ОХУ/, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/-д суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон бусад холбогдох байгууллагаас урьдчилан авна.

4.7. Гадаад улсаас ирэх иргэн дархлаажуулалтын бүрэн тун авсан эсэх мэдээллийг Дипломат төлөөлөгчийн газар, агаарын тээврийн компани болон автозам, төмөр замын боомтоор орж ирэх үед хил хамгаалах байгууллагаар дамжуулан авна.

4.8. Гадаад улсаас иргэдийг татан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр боловсруулж, батална.

4.9. Тусгаарлан ажиглах байрны өрөө, тасалгаа тус бүрийн орны тоо, байршлыг нарийвчлан судалж, иргэдийг байршуулах хуваарийг урьдчилан төлөвлөнө.

4.10. Тусгаарлан ажиглах байрны онцлог, багтаамж, давхар, өрөө тасалгаа, орны тоо, зохион байгуулалт, иргэний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилна.

4.11. Эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг урьдчилан бэлтгэсэн эмнэлэг, бусад зорчигчийг тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийг бэлтгэнэ.

4.12. Цагдаагийн байгууллага иргэнийг тусгаарлан ажиглах байранд хамгаалан хүргэх, тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.

4.13. УОКШШ-ын Онцгой байдлын ажилтан тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй онцгой байдлын алба хаагчаас ажиглалт хийж буй иргэний шилжилт хөдөлгөөний тоон мэдээ, эрүүл мэндийн ажилтнаас дэлгэрэнгүй бүртгэлийг өдөр бүр авч нэгтгэн, мэдээллийн санг баяжуулж, дүн шинжилгээ хийнэ.

4.14. Ажиглах байранд зайлшгүй шаардлагаар нэвтрэх /төрөлжсөн мэргэшлийн эмч мэргэжилтэн, өргөдөл, гомдлоор шалгалт хийх мэргэжлийн хяналтын улсын байцаагч, хэв журам сахиулах цагдаагийн алба хаагч, тусгаарлах байрны үйлчилгээ, цахилгаан, ус дулаан хангамж, мэдээлэл холбооны г.м/ ажилтан, албан хаагчдыг орох, гарах зөвшөөрөл олгоно.

4.15. Нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэний "ПГУ" шинжилгээний "сөрөг" гарсан сүүлийн хариуг тухайн өдрийн 11.00 цагаас өмнө албан бичиг эсвэл цахимаар авч, энэ талаар тусгаарлан ажиглах байрны хамгаалалтын ажилтанд мэдэгдэнэ.

4.16. Тусгаарлан ажиглах байрнаас орон нутаг руу явах иргэдийн мэдээллийг 48 цагийн өмнө аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт, нийслэлд гэрийн ажиглалтад шилжих иргэдийн мэдээллийг 24 цагийн өмнө нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.17. Тусгаарлан ажиглах байрны нөхцөл, дэг журам, эрүүл мэнд, хоол хүнсний асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэнэ.

4.18. Тусгаарлан ажиглах байрыг орчин нөхцөл, үйлчилгээний чанар, төлбөрийн нөхцөлөөс хамааруулан 3 зэрэглэлд ангилсан дэлгэрэнгүй судалгааг гаргаж, олон нийтэд санал болгоно.

4.19. АНСДШШ-ыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, шаардлагатай үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулна.

4.20. Удаа дараа зөрчил дутагдал гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг тусгаарлан ажиглах байраар ажиллуулахгүй байх шийдвэрийг гаргаж, гэрээг цуцлах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх санал гаргана.

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штабын эрх, үүрэг

5.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штаб тусгаарлан ажиглах байрны бэлтгэлийг хангуулна.

5.2. Тусгаарлан ажиглах байрны онцлог, багтаамж, давхар, өрөө тасалгаа, орны тоо, зохион байгуулалт, иргэний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилна.

5.3. Тусгаарлан ажиглах байрны удирдлага, ажилтан, алба хаагчдад сургалтыг аймаг, сум, дүүргийн Шуурхай штаб зохион байгуулж, мэдээллээр хангана.

5.4. АНСДШШ нь гэрийн тусгаарлалтад байгаа иргэний мэдээлэл, оршин суух хаяг, утасны дугаарыг нягтлан шалгаж, баг, хорооны Засаг даргад хүргүүлэн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, байнгын хяналт тавина.

5.5. Гэрийн тусгаарлалтад байгаа хүний эрүүл мэндийн хяналтыг дүүрэг, өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, тусгаарлалтын дэглэмийн мөрдөлт, дэг журмыг сум, дүүрэг, хороо, багийн цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтан хариуцна.

5.6. Сэжигтэй тохиолдол болон ойрын хавьтал, эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг эрүүл мэндийн байгууллагад, бусад зорчигчийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийн бэлтгэл, аюулгүй байдлыг хангуулна.

5.7. АНСДШШ нь тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэнийг халдвар сэргийлэлт, хяналтын дэглэм, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж тээвэрлэх ажлыг зохион байгуулна.

5.8. "CLIX GPS" систем ашиглан иргэнийг тусгаарлаж буй хаяг, байршилдаа байгаа эсэхэд цаг тухай бүр хянах ажлыг зохион байгуулж, гэрийн ажиглалтад биечлэн тавих хяналтыг өдөр 3 удаа заавал хэрэгжүүлнэ.

5.9. Иргэнийг гэрийн тусгаарлалтад байх хугацаанд биечлэн хяналт тавих эрх бүхий албан хаагч /баг, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч/-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, 7 хоног бүрийн Даваа гараг бүрийн 10 цагт clixsystem@cita.gov.mn хаягаар тайлан авч, нэгтгэнэ.

5.10. Тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжиж буй Улаанбаатар хотын харьяат иргэнийг /өөрийн эзэмшилгүй тээврийн хэрэгсэлгүй үед/ оршин суугаа газарт хүргэх ажлыг нийслэлийн Онцгой комиссын шуурхай штаб зохион байгуулна.

5.11. Орон нутагт Аймгийн Эрүүл мэндийн газраас тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэний "ПГУ" шинжилгээний "сөрөг" гарсан

сүүлийн хариуг тухайн өдрийн 11.00 цагаас өмнө албан бичиг эсвэл цахимаар авч, энэ талаар тусгаарлан ажиглах байрны хамгаалалтын ажилтанд мэдэгдэнэ.

5.12. Тусгаарлан ажиглах байрнаас аймаг, сум, орон нутаг руу явах иргэдийн мэдээллийг АНОКШШ-аас 48 цагийн өмнө аймаг, сумын Онцгой комиссын шуурхай штабт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.13. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй онцгой байдлын алба хаагчаас тусгаарлан ажиглах байранд байгаа иргэний шилжилт хөдөлгөөний мэдээг өдөр бүр авч, нэгтгэн УОКШШ-т цахимаар хүргүүлнэ.

5.14. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан хүн "CLIX GPS" систем ашиглаагүй, гар утсаа салгасан, хаяг байршилдаа байгаагүй, тусгаарлах байранд бусдыг нэвтрүүлсэн, эрүүл мэндийн мэдээллээ удаа дараа өгөөгүй, худал мэдүүлсэн, саад учруулсан зэрэг гэрээр тусгаарлах дэглэм, журмыг зөрчсөн тохиолдолд тухайн хүний байгаа газрыг яаралтай тогтоож, тусгаарлах ажиглах байр руу буцаан хүргэж, тусгаарлах ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх, зардлыг нөхөн төлүүлэх саналыг хууль хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

5.15. Хилийн боомтоор нэвтэрсэн хүнийг тусгаарлах байрны бэлтгэлийг хангуулах, тухайн нутаг дэвсгэрт тусгаарлах арга хэмжээг орон нутгийн онцгой комиссын Шуурхай штаб зохион байгуулна.

Зургаа. Хилийн нэвтрэх цэгт ажиллаж буй байгууллагуудын эрх, үүрэг

6.1. УОКШШ-аас ирүүлсэн нэрийн жагсаалтын дагуу улсын хилийн боомтоор татан авч буй зорчигчдыг тусгаарлан ажиглалтад шилжүүлэх эрэмбэлэн ангилах төлөвлөлтийг хилийн мэргэжлийн хяналтын алба хийнэ.

6.2. Хилийн мэргэжлийн хяналтын алба, хэлтсээс сэжигтэй зорчигчийн мэдээллийг нийслэлд ХӨСҮТ, орон нутагт эрүүл мэндийн байгууллагад өгнө.

6.3. Зорчигч бүрээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсаар асуумж судалгаа авч, биеийн халууныг хэмжин, хяналт тандалт хийж, зорчигчийг "сэжигтэй тохиолдол", "эрүүл мэндийн шалтгаантай" /түүний асран хамгаалагч,/, "бусад" "коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун хийлгэсэн" гэсэн дарааллаар ангилан тээврийн хэрэгслээс буулгана.

6.4. Зорчигч, түүний ачаа, гар тээшинд тусгайлан бэлтгэсэн байранд мэргэжлийн байгууллага халдваргүйжүүлэлт хийнэ.

6.5. Хил хамгаалах байгууллагын ажилтан нь халдвар сэргийлэлт, хяналтын дэглэмийг баримтлан зорчигчийн биеийн байцаалтыг шалган, улсын хилээр нэвтрэх зөвшөөрөл олгоно.

6.6. Сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд бусад зорчигчоос түр тусгаарлан, холбогдох байгууллагад мэдээлж, тэмдэглэл үйлдэн эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний багт шилжүүлнэ.

6.7. Сэжигтэй зорчигчийн ойрын хавьтлыг тогтоож, бусад зорчигчоос тусад нь тээврийн хэрэгсэлд суулган, эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад шилжүүлнэ.

6.8. Сэжигтэй зорчигчийн ойрын хавьтлыг буулгасны дараа эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг хуваарилсан тээврийн хэрэгсэлд суулган, эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

6.9. Шуурхай штабаас урьдчилан ирүүлсэн нэрийн жагсаалтын дагуу бусад зорчигчийг тээврийн хэрэгсэлд суулгаж цагдаагийн хамгаалалт дор тусгаарлан ажиглах байранд хүргэнэ.

6.10. Агаарын тээврийн компаниуд нь гадаад улсаас ирэх иргэний дархлаажуулалтын бүрэн тун авсан эсэх мэдээллийг УОКШШ-т хүргүүлнэ.

6.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины бүрэн тун авсан нотлох баримттай иргэнийг тусгаарлахгүй.

6.12. Нисэх багийн бүрэлдэхүүн, галт тэрэг, вагоны дарга, үйлчлэгч, улс хоорондын тээврийн хэрэгслийн болон автобусны жолооч, төмөр замын машинист, агент /хөлгийн ажилтан/, хилийн мэргэжлийн хяналт, цагдаа, тагнуул, хил, гааль, онцгой байдлын алба хаагч зэрэг үүрэг гүйцэтгэсэн ажилтнуудыг гэрийн тусгаарлалтад шилжүүлнэ.

Долоо. Тусгаарлан ажиглах байр (аж ахуйн нэгж)-ын эрх, үүрэг

7.1. Иргэнийг хүлээн авахын өмнө тэдгээрийн мэдээллийг УОКШШ, АНСДШШ урьдчилан авч, тусгаарлан ажиглах байрыг бэлтгэж, бэлэн байдлыг хангана.

7.2. Тусгаарлан ажиглах байрны байршил, давхар, өрөө, тасалгаа, нийт орны тоогоор зураглал гаргаж УОКШШ, АСДШШ-т хүргүүлнэ.

7.3. Тусгаарлан ажиглах байр цахилгаан, халаалт, усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цуглуулалт, зайлуулалт, иргэд, ажиллагчдын хоол, хүнсний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, ажиллагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдалд дотоод хяналтыг зохион байгуулна.

7.4 Тусгаарлан ажиглах байранд байгаа иргэн, ажиллагчдын хоол, хүнсний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавьж, чанартай, аюулгүй хоол, хүнсээр ханган, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хариуцна.

7.5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн, хаяг шошгын зөрчилгүй, хэрэглэх заавар тодорхой халдваргүйжүүлэх бодисоор батлагдсан зааврын дагуу угаалга, цэвэрлэгээг тогтмол хийлгэж, хог хаягдлыг тогтмол зайлуулж байгаад дотоодын хяналт тавьж ажиллана.

7.6. Ажиглалтын хугацаанд байрлаж ажиллах ажилтнуудын хувийн бэлтгэлийг бүрэн хангуулж, ээлж солихгүйгээр ажиллуулна.

7.7. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй харьцах, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, "ПГУ" шинжилгээнд бүрэн хамрагдсан тогооч, ажилтныг ажиллуулна.

7.8. Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэх эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

7.9. Тусгаарлан ажиглах байранд сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийн нөөцийг бэлтгэнэ.

7.10. Тусгаарлан ажиглалтад байгаа иргэний мэдээлэл, хувь хүний нууцыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусдад задруулахыг хориглоно.

7.11. Иргэн тусгаарлан ажиглах байрнаас гарсны дараа байр, өрөөнд халдваргүйжүүлэлт хийж дараагийн иргэнийг хүлээн авах бэлтгэлийг хангана.

7.12. Нэг ээлжийн тусгаарлан ажиглалтын хугацаа дуусмагц 2 хоногийн дотор хяналтын камерын бичлэгийн хуулбарыг тагнуул, цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Найм. Гал тогооны ажилтны эрх, үүрэг

8.1. Шуурхай штабаас боловсруулсан жишиг цэсэд нийцүүлэн баталсан 7 хоногийн хоолны цэс, технологийн картыг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулж, мөрдөнө.

8.2. Хоол үйлдвэрлэлийг эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан газарт явуулна.

8.3. Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой, баталгаажилттай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хоол үйлдвэрлэлд ашиглаж, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг тогтмол хөтөлнө.

8.4. Бэлтгэсэн хоол, хүнсний цуврал бүрээс 150 гр-аас доошгүй дээжийг ариутгасан саванд авч битүүмжлэн, хаяглаж, 4°C-ийн хэмд, 72 цагаас багагүй хугацаанд хадгалж, бүртгэл хөтөлсний дараа устгана.

8.5. Хоолны сав, хэрэгслийг 2 хувийн содын уусмал эсвэл зориулалтын угаагч бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

8.6. Хоолыг зориулалтын халуун баригч бүхий битүүмжлэлтэй саванд хийж, зөөвөрлөнө.

8.7. Хоол зөөх тэргэнцрийг 0.015 хувийн жавелион эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлнэ.

8.8. Тусгаарлах байранд байнга ажиллах ажилтантай шууд харьцах, гал тогооноос бусад хэсэгт зорчихыг хориглох ба халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдөнө.

8.9. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 сар тутамд бүрэн хамрагдсан байна.

8.10. Өөрийн эрүүл мэндийн байдал болон биеийн халуунд өдөр бүр хяналт тавьж, өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлах байрны эмч мэргэжилтэнд яаралтай мэдэгдэнэ.

Ес. Үйлчилгээний ажилтны эрх, үүрэг

9.1. Халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, хэрэглээний талаарх сургалтад хамрагдсан байна.

9.2. Ажиглалтад байгаа иргэн нийтийн эзэмшлийн шал болон бусад гадаргуу дээр бөөлжсөн, суулгасан тохиолдолд шингэнийг нэг удаагийн цаасан алчуураар шингээж авна. Бүхэл хэсгийг хутгуур ашиглан хамж авсны дараа угаалгын бодистой халуун усаар угааж цэвэрлэн шалыг 0.015 хувь, ариун цэврийн өрөөг 0.03 хувийн жавелионы уусмал эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлнэ.

9.3. Цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, хог хаягдал цуглуулах үедээ нэг удаагийн халат, малгай, нүдний шил эсвэл нүүрний хаалт, нэг удаагийн амны хаалт, нэг удаагийн бээлий дээр цэвэрлэгээний зузаан бээлийг өмсөнө.

9.4. Хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө, цэвэрлэгээ, үйлчилгээ хийсний дараа гар угаана.

9.5. Тогтоосон цагийн хуваарийн дагуу өрөөний үүдэнд гаргасан хатуу хог хаягдлыг цуглуулж, хог хаягдлын цэгт хүргэнэ.

9.6. Халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулан зөөвөрлөж, түр хадгалах хэсэгт хүргэж, цэвэрлэгээ, үйлчилгээний дараа хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлна.

9.7. Ажиглах өрөөний хаалганы гадна талын бариул, хонх, коридорын шал, явган хүний болон цахилгаан шат зэрэг хүний гар байнга хүрэлцэх гадаргууг өдөр бүр цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

9.8. Цахилгаан шат, хаалганы дээд хэсэг, коридорын болон хүлээлгийн танхимын гар хүрэхгүй хэсгийг шүршиж халдваргүйжүүлнэ.

9.9. Иргэнийг хүлээн авч, өрөөнд байрлуулсны дараа өрөөний хаалганы гадна тал, шат, цахилгаан шат, хүлээлгийн танхим, гадна хаалга, үүдний хэсэгт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийнэ.

9.10. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлахгүйгээр өөрийн амрах байр болон бусад хэсгүүдэд зорчихыг хориглоно.

Арав. Эрүүл мэндийн ажилтны үүрэг

10.1. Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акттай урьдчилан танилцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

10.2. Тусгаарлан ажиглах байрны өрөө, орны тоо, хуваарилалтад хяналт тавьж байршлаар нарийвчлан гаргасан судалгааны дагуу иргэнийг байрлуулж, урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлт, хяналтыг дагаж мөрдөх талаар зөвлөмж өгч тэмдэглэл үйлдэнэ.

10.3. Тусгаарлах байранд ажиллаж буй төрийн албан хаагч болон ажилтнуудад халдвар сэргийлэлт, хяналтын дэглэмийн зааварчилгаа өгч, удирдан зохион байгуулна.

10.4. Тусгаарлан ажиглах байранд шаардлагатай үед хэрэглэх эмнэлгийн анхны шатны болон яаралтай тусламжийн эм, хэрэгслийн нөөцөөр зарлагыг тогтмол хөтөлнө.

10.5. Иргэнээс батлагдсан загварын дагуу "Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас" бөглүүлж авна.

10.6. Ажиглалтад байгаа иргэний биеийн халууныг өдөрт 2-оос доошгүй удаа тодорхой зайнаас хэмжиж, тэмдэглэл хөтөлнө.

10.7. Өөрийн болон бусад (үйлчилгээний болон онцгой байдал, цагдаагийн) алба хаагчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, биеийн халууныг өдөр бүр хэмжиж, тэмдэглэл хөтөлнө.

10.8. Тусгаарлан ажиглах байр болон иргэний өрөөнд зайлшгүй шаардлагаар нэвтэрч байгаа эмч мэргэжилтэн, бусад ажилтны талаарх мэдээллийг тухай бүр бүртгэж, тэмдэглэл хөтөлнө.

10.9. Хоол түгээх, биеийн халуун хэмжих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед нэг удаагийн халад, малгай, эмнэлгийн амны хаалт, үзлэгийн бээлий, гутлын гадуурх улавч хэрэглэнэ.

10.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол илэрсэн үед иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийг өмсөж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

10.11. Гал тогооноос иргэдийн хоол, цайг хүлээн авч, ажиглалтын өрөөний үүдэнд байрлуулсан ширээн дээрх аяга, тавагны гадна талд бээлийтэй гараар хүрэхгүйгээр хоолыг хийж түгээнэ.

10.12. Хоол түгээж дууссаны дараа хоолны сав, хэрэгслийг гал тогооны бохир хүлээн авах хэсэгт хүргэнэ.

10.13. Хүнд ямар нэгэн зовуурь, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед үзлэг хийж, тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

10.14. Хэрэв иргэнд эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол харьяалах эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэж, тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлнэ.

10.15. Тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу зөв тайлж, халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулна.

10.16. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө гарыг угааж, халдваргүйжүүлнэ.

10.17. Иргэн тавьсан шаардлагыг эсэргүүцэх, доромжлох, заналхийлэх, биед нь халдах зэрэг үйлдэл гаргасан тохиолдолд онцгой байдлын болон цагдаагийн алба хаагчид мэдэгдэнэ.

10.18. Иргэний овог, нэр, нас, хүйс, аяллын товч түүх, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг, тусгаарлалтад орсон, шилжсэн, гарсан огноо, эрүүл мэндийн мэдээлэл зэргийг УОКШШ, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын "Нэмэлт мэдээлэл" талбарт 24 цагийн дотор байршуулна.

10.19. Тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжиж буй хүнд гэрийн ажиглалтад мөрдөх дэглэм, журмыг танилцуулж, баталгааны хуудсыг тухайн хүнээр 2 хувь үйлдүүлж, 1 хувийг өөрт нь, нөгөө хувийг цагдаагийн алба хаагчид хүлээлгэн өгнө.

Арван нэг. Онцгой байдлын алба хаагчийн эрх, үүрэг

11.1. Тусгаарлан ажиглах байрны дотоод үйл ажиллагаанд хяналт тавьж, аюулгүй байдлыг хангах үүргийг 24 цагийн турш гүйцэтгэнэ.

11.2. Иргэний эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах ба эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагын алба хаагчтай хамтран ажиллана.

11.3. Тусгаарлан ажиглах байрны галын аюулгүй байдал, аврах зам, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, хэвийн ажиллагаанд хяналт тавьж, урьдчилан сэргийлнэ.

11.4. Ажиглалтад байгаа иргэнд ирсэн эргэлтийн эд зүйлсийг дундын бүс /шар/-ээс авч, эмч мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

11.5. Тусгаарлан ажиглах байранд байгаа иргэний шилжилт хөдөлгөөний мэдээг өдөр бүр нийслэлд УОКШШ, орон нутагт аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт өгнө.

11.6. Иргэнийг тусгаарлан ажиглах байранд хүлээн авч, байрлуулахад эмч мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх, иргэний санал, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч, тэмдэглэл хөтлөн шийдвэрлүүлнэ.

11.7. Үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр тэмдэглэл хөтөлж, илэрсэн зөрчил, дутагдлын талаар УОКШШ-т мэдэгдэнэ.

11.8. Тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэнд гар утсандаа "CLIX GPS" системийг суулгах, ашиглах заавар, зөвлөмжийг өгч, мэдээллээ бүрэн гүйцэд оруулсан эсэхэд хяналт тавина.

11.9 "CLIX GPS" системийг суулгасан болон суулгах боломжгүй иргэний мэдээллийг УОКШШ -т хүргүүлнэ.

Арван хоёр. Цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг

12.1. Тусгаарлан ажиглах байрны гадна орчин хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг тэмдэглэгээг нийтэд харагдахуйц байдлаар байршуулж, хэв журам сахиулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгслийг хамгаалж байгаа объект, бүсэд нэвтрүүлэхгүй байна.

12.2. Тусгаарлан ажиглах байранд нэвтрэх шаардлагатай эмч мэргэжилтэн, эрх бүхий байгууллагаас зөршөөрөлтэй албан хаагчийн ажлын үнэмлэх, хүчин төгөлдөр "ПГУ" шинжилгээний хариуг шалгаж, бүртгэл хөтлөн нэвтрүүлнэ.

12.3. Тусгаарлан ажиглах байранд хориглосон эд зүйлсийг нэвтрүүлэхгүй байх зорилгоор ачаа тээш, эд зүйлсэд үзлэг хийж гэрчээр эмч, онцгой байдлын алба хаагчийг байлцуулан тэмдэглэл хөтөлнө. Иргэний биед ижил хүйсний алба хаагчаар үзлэгийг хийлгэнэ.

12.4. Энэхүү журмаар хориглосон эд зүйлсийг тусгаарлан ажиглах байр руу нэвтрүүлэхгүй байх бөгөөд буцаах боломжгүй бол бүртгэл хөтлөн түр хадгалж, иргэнийг тусгаарлалтаас гарах үед хүлээлгэн өгнө.

12.5. Тусгаарлагдаж байгаа иргэн, үүрэг гүйцэтгэж буй бусад албан хаагчдад хууль ёсны шаардлага тавьж, гарсан гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоож, энэ талаар тэмдэглэл үйлдэн нэн даруй удирдах албан тушаалтанд мэдэгдэж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлнэ.

12.6. Хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай штабт 10.00 цаг, 18.00 цаг, 24.00 цагт мэдээ өгч, тэмдэглэл хөтөлнө.

12.7. Тусгаарлан ажиглах байранд гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий дипломат ажилтныг тусгаарлах тохиолдолд "Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ийн 36 дугаар зүйлд заасныг баримтлах бөгөөд биед нь болон түүний ачаа тээшинд үзлэг хийх тохиолдолд Монгол Улсын Гадаад харилцааны яаманд мэдэгдэж, тухайн дипломат ажилтныг харьяалах Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл түүний бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.

12.8 Тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжиж буй иргэний баталгааны хуудасны нэг хувийг эмчээс авч, журам зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг сануулна.

Арван гурав. Иргэний эрх, үүрэг

13.1. Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэж буй эмчийн хуваарилсан өрөөнд тусгаарлагдаж, тогтоосон хугацаанд тусгаарлалтын дүрэм, журмыг мөрдөнө.

13.2. Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

13.3. Иргэн тусгаарлан ажиглах байранд орохоос өмнө өөрийн эрүүл мэнд байдал, шашны зан үйлээр хориглосон болон харшлах, эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг урьдчилан мэдэгдэнэ.

13.4. Тусгаарлан ажиглалтын хугацаанд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-т тусгасан сорьц цуглуулах давтамжийн дагуу шинжилгээнд хамрагдана.

13.5. Ажиглалтад байгаа иргэн өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ талаар нэн даруй мэдэгдэнэ.

13.6. Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байж, эмч мэргэжилтэн болон бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зайг барина.

13.7. Өрөөний цонхны салхивчийг 2 цаг тутамд 15 минут нээж, агааржуулалт хийж, зааврын дагуу гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сахина.

13.8. Зааварчилгааны дагуу өрөөний цэвэрлэгээг өдөр тутам хийж, ахуйн хог хаягдлыг хуваарийн дагуу өрөөний үүдэнд гаргаж тавина.

13.9. Байрны эд хогшлыг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглаж, тухайн байгууллагын дотоод журамтай танилцаж гарын үсэг зурна.

13.10. Гадаад улсаас татан авалтаар ирэх хүн тусгаарлан ажиглах байрны нөхцөл, тавих шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тарифын дагуу ажиглалтын байрны төлбөрийг урьдчилан төлнө.

13.11. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй болон ойрын хавьтлаар тогтоогдсон тохиолдолд шинжилгээ өгөх, эрүүл мэндийн байгууллагад тусгаарлагдан эмчилгээ, үйлчилгээнд хамрагдана.

13.12. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай болох нь батлагдсан тохиолдолд өөрийн уулзсан хүн, явсан зам, чиглэлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдээлнэ.

13.13. Бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хариуцна.

13.14. Тусгаарлан ажиглалтад байгаа иргэнд дараах үйлдлийг хориглоно.

- ажилтан, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, доромжлох, заналхийлэх, биед нь халдах, аливаа зүй бус үйлдэл гаргах.

- тусгаарлан ажиглах байранд бусдын эрүүл мэндэд хохирол учруулахуйц хурц үзүүртэй эд зүйл, архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах эм, эмийн хэрэгсэл, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн авч орох, хэрэглэх, эргэлтээр авах.

- өрөөнөөс гарах, өрөөний цонхоор хог, тамхины иш, нус, цэр, шүлсээ хаях болон эд зүйл дамжуулах, бусадтай харилцах.

- бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, өдөөн турхирах, буруу ташаа мэдээлэл тараах болон түгээх.

13.15. Тусгаарлан ажиглах байрнаас гарах үед иргэн өөрийн ачаа тээшийн гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий уусмалаар арчиж халдваргүйжүүлнэ.

13.16. Тусгаарлан ажиглах байрнаас гарахаас өмнө гар утсандаа "CLIX GPS" системийг суулгаж, ашиглах заавар, зөвлөмжтэй танилцаж, гэрээр ажиглах журамтай танилцаж, баталгааны хуудсанд гарын үсэг зурж өгнө.

Арван дөрөв. Тусгаарлан ажиглах байранд эргэлт оруулах ажиллагаа

14.1. Тусгаарлан ажиглах байранд байгаа иргэнд энэ журмын 15.2-т заасан хориглоогүй эд зүйлсийг долоо хоногт нэг удаа эргэлтээр оруулж болно.

14.2. Тусгаарлан ажиглах байранд байгаа иргэнд цагаан хэрэглэл, ахуйн болон ариун цэврийн хэрэглэл (шүдний оо, сойз, шампунь, ангижруулагч, саван, гоо сайхны бүтээгдэхүүн, алчуур, ариун цэврийн цаас, живх, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч бодис) хувцас, гутал, бичгийн хэрэгсэл, ном, сонин, сэтгүүл, гар утас, сим карт, нэгж, компьютер, техник хэрэгсэл, хүүхдийн тоглоом, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан, зориулалтын савлагаатай, бүрэн бүтэн байдал нь алдагдаагүй, хүнсний бүтээгдэхүүн (талх, нарийн боов, чихэр, цай, кофе, ёотон, сүү, тараг, жимс, хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хүнс г.м.) хүүхдийн угж, хооллох хэрэгсэл зэргийг гэрэлтдэг уутанд хийж, эд, зүйлсийн жагсаалт, тоо ширхэгийг бичиж оруулахыг зөвшөөрнө.

14.3. Эргэлтийг 10.00-16.00 цагийн хооронд тусгаарлан ажиглах байрны тогтсон нэг хаалгаар хүлээн авна.

14.4. Эргэлт хүлээн авахад эмч мэргэжилтэн, албан хаагчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулна.

14.5. Эргэлтийн эд зүйлд цагдаагийн алба хаагч үзлэг хийж, энэ журмын 14.14-д заасан хориглосон эд зүйлсийг буцаана.

14.6. Эргэлтийн эд зүйлийг цагдаагийн алба хаагч "ногоон" бүсэд хүлээн авч зөвшөөрөгдсөн эд, зүйлсийг завсрын буюу "шар" бүсэд хүргэнэ.

14.7. Цагдаагийн албан хаагч дундын бүсэд эд зүйлсийг байршуулсны дараа онцгой байдлын алба хаагч хүлээн авч "улаан" бүсэд эмч мэргэжилтэнд дамжуулан өгнө.

14.8. Тусгаарлан ажиглах байранд өөрийн болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй хурц, шовх үзүүртэй эд зүйлс, согтууруулах, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт, халуун бууруулах, өвчин намдаах эм, бодис, хагас боловсруулсан, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн, олон хүн тоглох тоглоом /хөзөр, хөлөгт тоглоом гэх мэт/ зэргийг оруулахыг хориглоно.

14.9. Ар гэрээс нь эргэлт өгөх боломжгүй үед тусгаарлан ажиглах байрны эрх бүхий ажилтанд хүсэлт гаргаж зөвшөөрөгдсөн эд зүйлсийг худалдан авч болно.

Арван тав. Тусгаарлан ажиглах байранд иргэнээс шинжилгээ авах, сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үеийн хариу арга хэмжээ

15.1. Тусгаарлан ажиглагдаж байгаа иргэн /гадаадаас ирсэн/-ээс "ПГУ" шинжилгээний анхны сорьцыг ХӨСҮТ-ийн шуурхай хариу арга хэмжээний баг, 2 дах буюу давтан шинжилгээг 8 дах хоногт аймаг, нийслэл, дүүргийн шуурхай хариу арга хэмжээний баг авна.

15.2. Тусгаарлан ажиглагдаж байгаа ойрын хавьтлыг иргэнээс "ПГУ"-ийн давтан шинжилгээг харьяа нутаг дэвсгэрийн шуурхай хариу арга хэмжээний баг 6 дах хоногт авна.

15.3. Тусгаарлан ажиглах байрны эмч мэргэжилтэн, иргэн, үүрэг гүйцэтгэж буй ажилтан, албан хаагчдад коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн

тохиолдолд коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа эсэхийг үнэлнэ.

15.4. Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа иргэнийг өрөөнд нь, ажилтан, албан хаагчдыг урьдчилан бэлтгэсэн түр тусгаарлах өрөөнд тусгаарлаж, нийслэлд ХӨСҮТ (119, 100, 80086829 дугаарын утас), орон нутагт аймгийн эрүүл мэндийн газар, бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, багийн эрүүл мэндийн төвд мэдэгдэж шилжүүлнэ.

15.5. Нэг өрөөнд тусгаарлагдсан 0-16 насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн аль нэгээс коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвшөөрлийн дагуу эрүүл мэндийн байгууллагад хамтад нь шилжүүлж болно.

15.6. Гэр бүлийн болон хамт амьдарч, ажиллаж сурч байсан зарчмаар нэг өрөөнд тусгаарлагдсан тохиолдолд сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж, бусад иргэнийг өрөөнд нь тусгаарлан ажиглана.

15.7. Батлагдсан тохиолдлыг тусгаарлан ажиглах байрнаас шилжүүлсний дараа нийслэлд ЗӨСҮТ, аймагт Зоонозын өвчин судлалын төв, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд сум, тосгоны эрүүл мэндийн төвийн халдваргүйжүүлэлтийн мэргэжлийн багаар, байрлаж байсан өрөө, түр тусгаарлах өрөө, байранд явсан чиглэлийн дагуу голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийлгэнэ.

15.8. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх үед тухайн нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, хяналт хийлгэнэ.

15.9. Халдваргүйжүүлэлт хийсэн хэсгүүдийг халдваргүйжүүлэх бодисын хэрэглэх аюулгүй ажиллагааны зааврын дагуу угааж цэвэрлэнэ.

15.10. Эмнэлэг, сувиллаас бусад байрыг тусгаарлан ажиглах байраар ашиглаж байгаа бол батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрсэн үед түүний хог хаягдлыг аюултай хог хаягдал гэж тооцон, халдваргүйжүүлэлт хийсэн байгууллагад битүүмжлэн өгч явуулна.

15.11. Тусгаарлан ажиглах байрны эрүүл мэндийн ажилтан нь батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрч, эмнэлгийн байгууллага руу хүргэгдсэн иргэний талаархи мэдээллийг 1 цагийн дотор УОКШШ, НОКШШ-т тус тус мэдэгдэнэ.

15.12. Ганцаараа тусгаарлагдах боломжгүй /өөрийн үйлдэл холбогдлын хянах чадваргүй, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, бүрэн бус чадвартай/ иргэний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тусгаарлах байр руу оруулж, хамтад нь тусгаарлаж болно.

Арван зургаа. Тусгаарлан ажиглах байрны халдваргүйжүүлэлт

16.1. Тусгаарлан ажиглах байранд урьдчилан сэргийлэх, ажиглалтын хугацаанд, тусгаарлалт дууссаны дараа объектод халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага болон тухайн байрны үйлчилгээний ажилтан холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

16.2. Тусгаарлан ажиглалтад оруулж байгаа иргэнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлнэ.

16.3. Тусгаарлан ажиглалтад байгаа иргэн, ажилчдаас коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд тухайн иргэний байрлаж байсан өрөө, ажилтны амралтын өрөө, явсан чиглэлийн дагуу коридор, шат, лифт, хаалганы хэсэгт

голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, холбогдох мэргэжлийн байгууллага, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг гүйцэтгэнэ.

Арван долоо. Тусгаарлан ажиглах байранд тавих хөндлөнгийн хяналт

17.1. Мэргэжлийн хяналтын байгууллага нь тусгаарлан ажиглах байранд дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

17.1.1. Тусгаарлан ажиглах байрны эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм, хоол хүнсний аюулгүй байдлын талаар ирүүлсэн өргөдөл гомдол, удирдлагын шийдвэрийн дагуу болон явцын хяналт шалгалтыг хийж, зөрчил, дутагдлыг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

17.1.2. Тусгаарлан ажиглах байранд хийж байгаа халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээнд хяналт тавих;

17.1.3. Батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрсэн үед хийх голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хяналт тавих.

17.2. Тусгаарлан ажиглах байрны хөндлөнгийн хяналтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тагнуул, цагдаагийн байгууллага хэрэгжүүлнэ.

17.3. Тусгаарлан ажиглах байранд хяналт тавих этгээд шаардлагатай тохиолдолд камерын бичлэгийг ашиглана.

Арван найм. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах ажиллагаа

18.1. Тусгаарлан ажиглах байр, өрөө, хоол үйлдвэрлэл, харуул, үйлчилгээ, хяналтын ажилтны хэсгээс гарах ариун цэврийн цаас, шил, лааз, сав, хайрцаг зэрэг баглаа боодол, хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдлийг энгийн хог хаягдлын хар өнгийн уутанд цуглуулна.

18.2. Тусгаарлан ажиглах байранд үүрэг гүйцэтгэж байгаа эмч мэргэжилтэн, алба хаагч болон бусад ажилтны хэрэглэсэн хамгаалах хувцас, хэрэгсэл (нэг удаагийн амны хаалт, бээлий, халат, нүдний шил, нүүрний хаалт, малгай, гутлын улавч болон тарианы хөвөн, дуслын системийн зүүгүй хэсэг, живх зэрэг)-ийг шар өнгийн уутанд цуглуулна.

18.3. Тусгаарлан ажиглах байранд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон гэрийн нөхцөлд эмчилгээ хийлгэсэн тохиолдолд хэрэглэсэн тарианы ампул, зүү, тариур зэрэг хурц үзүүр, иртэй хог хаягдлыг аюулгүй хайрцагт цуглуулна.

18.4. Халуун хэмжигч багажийн зай, өдрийн гэрэл, даралт хэмжигч зэрэг хүнд металл агуулсан, хугацаа дууссан, хагарч гэмтсэн, бохирдсон эм, халдваргүйжүүлэх бодис агуулсан сав зэргийг хүрэн өнгийн уутанд цуглуулна.

18.5. Тусгаарлан ажиглах байр болон гэр, амрах байрнаас гарсан хог хаягдалд нийслэлд ЗӨСҮТ, тусгай зөвшөөрөл бүхий аж, ахуйн нэгж байгууллага, аймаг, суманд ЗӨСТ, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг халдваргүйжүүлэлт хийнэ.

18.6. Хог хаягдалд халдваргүйжүүлэлт хийсэн тухай актыг 2 хувь үйлдэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэг хувийг өгнө.

18.7. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан шар, хүрэн өнгийн ууттай болон аюулгүй хайрцагтай хог хаягдлыг өдөрт 1 удаа тухайн байрны хог хаягдлыг цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

18.8. Тусгаарлан ажиглах болон хамгаалалтад авсан байрнаас гарсан энгийн хог хаягдлыг тохижилт үйлчилгээний компани тээвэрлэж устгана.


18.9. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан аюултай болон ахуйн хог хаягдлыг нийслэлд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад, орон нутагт тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад авна.

Арван ес. Бусад

19.1. Ажил үүргийн хувьд олж мэдсэн хувь хүний нууцыг албан тушаалтан задруулах байх үүрэг хүлээнэ.

19.2. Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд “Эрүүгийн хууль”, “Гамшгаас хамгаалах тухай” хууль, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тусгаарлан ажиглах үйл
ажиллагааг зохицуулах түр журмын
хавсралт



ТУСГААРЛАГДСАН ИРГЭНИЙ СУДАЛГААНЫ ХҮСНЭГТ


Тусгаарлах байрны нэр:

Тусгаарлах байрны хаяг:

№	Овог, нэр	Нас	Хүйс	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн хаяг	Оршин суух буюу тусгаарлалтад байх хаяг	Байнга ашиглах утасны дугаар/суурин болон гар утас	Шардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар	Тусгаарлан ажиглах байр		Гэртээ тусгаарлах боломжтой эсэх
									Орсон огноо	Гарах огноо	

Жич: Гэртээ тусгаарлах боломжтой эсэхийг асууж тодруулан /нялх хүүхэдтэй, өндөр настантай, ам бүл олуулаа болон бусад/ иргэн өөрийн хүсэлтээр тухайн байранд тусгаарлалтыг үргэлжлүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Улсын онцгой комиссын даргын
2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
00 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ГЭР (АМРАХ БАЙР)-Т ТУСГААРЛАН АЖИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр (амрах байр)-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам /цаашид “журам” гэх/ нь тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжиж байгаа болон коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтлыг гэрийн тусгаарлалтад хянах, оролцогч талуудын үүрэг, хариуцлага, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Гэрийн тусгаарлалт гэдэг нь тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжиж байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтал болсон хүнийг гэр бүл, хамтран амьдрагчтай нь хамт орон байр, гэр, сууцанд, ажиллах хүчний хувьд нэг ээлжийн хүмүүсийг амрах байранд нь төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хяналтад байлгахыг хэлнэ.

1.3. Гэрийн тусгаарлалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд Улсын онцгой комиссын Шуурхай штаб, орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штаб нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

1.4. Гэрийн тусгаарлалтыг хянах үйл ажиллагааны баримт бичгийг хуулийн этгээд бусдад шилжүүлэх, дамжуулахдаа цахим гарын үсэг хэрэглэнэ.

1.5. Иргэнийг тусгаарлан ажиглах үед дараах зарчмыг баримтална:

- 1.5.1. Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;
- 1.5.2. Хууль дээдлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх;
- 1.5.3. Шуурхай, ил тод, нээлттэй байх;
- 1.5.4. Хувь хүний нууцыг чанд хадгалах;

Хоёр. Гэрийн тусгаарлан ажиглалтын хугацаа

2.1 Тусгаарлан ажиглах хугацааг дараах байдлаар тогтооно:

2.1.1. Гадаад улсаас ирж байгаа коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамрагдаагүй буюу бүрэн тун хийлгээгүй тусгаарлан ажиглах байрнаас гэрийн ажиглалтад шилжиж байгаа Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн болон харьяалалгүй хүнийг гэрийн тусгаарлалтад 4 хоног;

2.1.2. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтлыг гэрийн тусгаарлалтад 7 хоног;

2.1.3. Халдварын голомтот бүс нутгаас ирсэн, халдварын голомтод ажилласан албан хаагч, ажилтан, иргэнийг гэрийн тусгаарлалтад 7 хоног;

2.1.4. Халдвар бүртгэгдээгүй бүс нутагт халдварын голомтот бүс нутгаас ирж ажилласан албан хаагч, ажилтантай хамт ажилласан хүнийг 7 хоног тухайн орон

нутагт нь гэрийн тусгаарлалтад тус тус ажиглана.

2.2. Гэрийн тусгаарлалтад орсон иргэний гэр бүлийн гишүүдийг гэрийн тусгаарлалтад байх хоногоор хамт тусгаарлана.

Гурав. Иргэний эрх, үүрэг

3.1. Гадаад улсаас ирж, тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжиж байгаа, коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтлаар гэртээ тусгаарлагдсан иргэн харьяалах анхан шатны эрүүл мэндийн байгууллага (өрх, сум, тосгон)-д мэдэгдэнэ.

3.2. Иргэн гар утсандаа "CLIX GPS" систем суулгаж, гар утсаа унтраалгүй, шуурхай штабаас ирсэн дуудлага заавал хариулах, хаяг байршлаасаа гарахгүй байх, тусгаарлах байранд бусдыг нэвтрүүлэхгүй байх, эрүүл мэндийн мэдээллээ үнэн зөв өгөх, гэрээр ажиглах ажилд хяналт тавьж буй албан хаагчдын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, гэрээр тусгаарлах дэглэм, журмыг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ.

3.3. Оршин суух буюу өөрийгөө тусгаарлах хаяг байршил, мэдээллээ бүртгүүлэх, тухайн хаяг, байршилдаа Улсын онцгой комиссоос тогтоосон хугацаанд гарах хөдөлгөөн хийхгүйгээр байрлана.

3.4. АНСДШШ, гэрийн ажиглалтад хяналт тавих үүрэг хүлээсэн Засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж буй ажилтан, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

3.5. Гэрийн тусгаарлалтын хугацаанд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-т тусгасан сорьц цуглуулах давтамжийн дагуу шинжилгээнд хамрагдана.

3.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай болох нь батлагдсан тохиолдолд өөрийн уулзсан хүн, явсан зам, чиглэлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдээлнэ.

3.7. Биеийн халуунаа өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, өөрийн эрүүл мэндийн байдлыг хянаж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах өрх, сум, тосгоны эмчид баталгааны хуудсан дээрх утсаар мэдэгдэнэ.

3.8. Тусгаарлагдсан иргэн ямар нэгэн зовиур илэрсэн, зөвлөгөө авах шаардлага гарсан даруйд хяналтын эмчид утсаар хандана.

3.9. Тусгаарлагдсан иргэнд халуурах, хоолой хөндүүрлэх, хуурай ханиалгах, ядарч сульдах шинж тэмдэг илэрвэл анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч, 119, ХӨСҮТ-ийн 100 болон 80086829 дугаарын утсанд хандана.

3.10. Томуу, томуу төст өвчний шинж тэмдгээс бусад төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч болон 119 дугаарын утсанд хандана.

3.11. Хэрэв гадаад улсын иргэн бол Интермед эмнэлгийн 80105577, SOS medical эмнэлгийн 91913122 утсанд хандаж, зөвлөгөө авна.

3.12. Гэрийн тусгаарлалтад байх хугацаанд тусгаарлагдаж буй газрын байршлыг солих, тухайн газраас гарах, зочин урих, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг эрсдэлд оруулахыг хориглоно.

3.13. Бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл, аюулгүй байдлыг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үүрэг хүлээнэ.

3.14. Гэртээ 2 цаг тутамд агаар сэлгэлт хийж, зөвлөмжийн дагуу гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сахина.

3.15. Эмч, мэргэжилтэн болон бусад албаны хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зай барина.

3.16. Тусгаарлагдах хугацаанд гарсан ахуйн хог хаягдлыг уутанд хийж, амыг нь сайтар боож цуглуулан, орон сууцанд амьдардаг бол хаалганы гадна, гэр хороололд амьдардаг бол хогийн саванд хийнэ. Хог хаягдал ил задгай хаяхыг хориглоно.

3.17. Гэрийн ажиглалтад байгаа иргэн нь дүрэм, журам зөрчсөн тохиолдолд хөдөлгөөнийг хянах зорилгоор гэрийн ажиглалтын байрны хаалга, цонхонд хяналтын тусгай тэмдэглэгээ бүхий анхааруулах хуудас хэрэглэж болно.

3.18. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн нөхцөлд хүлээлгэх хариуцлагын талаархи сануулсан баталгааны хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулан эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгч, хууль тогтоомжийг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ.

3.19. Гэрээр тусгаарлахтай холбоотой дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн, гар утсаа унтраасан, байршлын талаарх мэдээллийг хяналт тавьж буй байгууллагад тухай бүр нь мэдээлээгүй, тусгаарлагдаж буй байршлаас хугацаа дуусаагүй байхад гарсан, тусгаарлагдаж буй байрандаа бусдыг нэвтрүүлж, эрсдэлд оруулсан нөхцөлд хуулийн хариуцлага хүлээлгэж, ажиглах хугацааны үлдсэн хоногийн тоогоор тусгаарлах ажиглах байр руу шилжүүлж болно. Шилжүүлэхтэй холбоотой үүдэн гарах зардлыг тухайн этгээд өөрөө хариуцан төлнө.

Дөрөв. Бүх шатны онцгой комиссын Шуурхай штабын эрх, үүрэг

4.1. Улсын онцгой комиссын Шуурхай штаб нь бүх шатны шуурхай штабын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, шаардлагатай үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулна.

4.2. Улсын онцгой комиссын Шуурхай штаб нь тусгаарлан ажиглах байрнаас гарах хүний мэдээллийг 48 цагийн өмнө аймаг, нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабт цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.3. Аймаг, нийслэлийн онцгой комиссын Шуурхай штаб нь гэрийн тусгаарлалтад байгаа иргэнийг "CLIX GPS" системээр хянах ажлыг хариуцан зохион байгуулж сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, шаардлагатай үүрэг чиглэл өгч, биелэлтэд хяналт тавина.

4.4. Сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штаб нь гэрийн тусгаарлалтад байгаа иргэний мэдээлэл, хаяг, утасны дугаарыг нягтлан шалгаж, дэг журмыг сахиулах ажлыг бусад байгууллагуудтай хамтран, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хяналт тавина.

4.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штаб нь тусгаарлан ажиглах байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих иргэнийг тээвэрлэх үеийн халдварын сэргийлэлт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, гэрийн ажиглалтад байх хугацаанд "CLIX GPS" системийн болон биечлэн хяналт хийх үйл ажиллагааг зохион байгуулж, байнгын хяналт тавина.

Тав. Баг, хорооны Засаг даргын үүрэг

5.1. Харьяалах нутаг дэвсгэрт батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтал бүртгэгдсэн үед ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, иргэнийг хянах ажилтнуудын хуваарь, хяналт тавих үүрэг, чиглэлийг урьдчилан гаргаж, батална.

5.2. Харьяалах нутаг дэвсгэрийн гэрийн тусгаарлалтын мэдээнд үндэслэн иргэнийг хянах ажилтан /эрүүл мэнд, цагдаа, улаан загалмай, баг, хорооны нийгмийн ажилтан гэх мэт/-ыг томилон, тусгаарлагдсан иргэн болон гэр бүлийн бусад гишүүдийг бүртгэн авна.

5.3. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэнийг "CLIX GPS" системээр хянах ажлыг хариуцаж, системийн хяналтаас гадна биечлэн хяналт тавих, ухаалаг гар утасгүй болон "CLIX GPS" системийн хяналтаас гарсан хүний тусгаарлагдаж буй хаягаар цагдаа, онцгой байдлын алба хаагчидтай хамтран хяналт тавьж, хаана байгаа нь тодорхойгүй иргэнийг эрэн хайх ажлыг зохион байгуулна.

5.4. Тусгаарлагдсан иргэнд шаардлагатай ус, түлш, хүнс, эм гэх мэт нэн шаардлагатай зүйлсээр хангах асуудлыг зохион байгуулна.

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

6.1. Аймаг, нийслэлд коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг эмнэлэгт хэвтүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байгаа оношилгоо, эмчилгээний зааврын дагуу эмчилнэ.

6.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хавьтлын тандалт судалгаа, мэдээллийн урсгал:

6.2.1. Нийслэлд ХӨСҮТ, орон нутагт аймгийн Эрүүл мэндийн газар батлагдсан тохиолдлын талаархи мэдээллийг тухайн шатны шуурхай хариу арга хэмжээний багт өгнө.

6.2.2. Батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтлыг тухайн шатны Эрүүл мэндийн байгууллага, шуурхай хариу арга хэмжээний баг тогтоож, хяналтанд авна.

6.2.3. Аймаг, нийслэлийн шуурхай хариу арга хэмжээний баг батлагдсан тохиолдлын ойрын болон хоёрдогч хавьтлын эрүүл мэндийн эрсдэл /жирэмсэн, архаг суурь өвчтэй, сэтгэцийн эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн, гемодиализ, хавдрын хими, туяа гэх мэт өдөр тутмын эмчилгээ асаргаа шаардлагатай/-тэй эсэхийг нарийвчлан судалгааг хийж, тухайн шатны хариу арга хэмжээний багт, хаяг, байршлын мэдээллийг аймаг, нийслэлийн түргэн тусламжийн төвд тус тус хүргүүлнэ.

6.2.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай хариу арга хэмжээний баг нь иргэний овог, нэр, нас, хүйс, аяллын товч түүх, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг, тусгаарлалтад орсон, шилжсэн, гарсан огноо, эрүүл мэндийн мэдээлэл зэргийг УОКШШ, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын "Нэмэлт мэдээлэл" талбарт 24 цагийн дотор байршуулна.

6.2.5. ХӨСҮТ-ийн шуурхай удирдлагын нэгж нь дээрх мэдээллийг нэгтгэн, Эрүүл мэндийн яамны eochealth2014@gmail.com цахимт хүргүүлнэ.

6.2.6. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэний мэдээллийг анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага нийслэлийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлнэ.

6.2.7. Нийслэлийн эрүүл мэндийн газраас гэрийн тусгаарлалтад байгаа иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийг өдөр бүр НОК, УОК, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Анхан шатлалын тусламжийн хэлтэст хүргүүлнэ.

6.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрх, үүрэг

6.3.1. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн хяналт хийхэд удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангана

6.3.2. Сум, дүүрэг, өрх, тосгоны Эрүүл мэндийн байгууллагын Шуурхай хариу арга хэмжээний баг нь “Гэрийн тусгаарлалтын баталгааны хуудас”-ыг бөглүүлж, 1 хувийг сум, дүүргийн Шуурхай штабын Цагдаагийн албан хаагчид цахимаар хүргүүлнэ.

6.3.3. Шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрийн ажиглалтад байгаа иргэнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээллийг шуурхай авах үйл ажиллагааг зохицуулна.

6.3.4. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэнд тавьж буй эрүүл мэндийн хяналт, үр дүнгийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.

6.3.5. Тусгаарлагдсан иргэний эрүүл мэндэд хяналт тавих үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж байгаа иргэнийг холбогдох байгууллагад уламжилна.

6.4. Өрх, сүм, тосгоны эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

6.4.1. Харьяалах нутаг дэвсгэрийн гэрийн тусгаарлалтын мэдээнд үндэслэн иргэнийг хянах эмнэлгийн мэргэжилтнийг томилон, тусгаарлагдсан иргэн болон гэр бүлийн бусад гишүүдийг бүртгэн авна.

6.4.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас тусгаарлагдсан иргэнд биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийн талаар мэдээлэх, зөвлөгөө авах, нээлттэй утасны дугаарыг тэмдэглүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Батлагдсан тохиолдлын хавьтлын ажиглалтын хуудас”, бөглөх зааврыг танилцуулна.

6.4.3. Эрүүл мэндийн талаар мэдээлэх хугацаа, халдвар сэргийлэлт, хяналтын дэглэм, ажиглалтад байх иргэн болон түүний гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг сануулж, утсаа байнга нээлттэй байлгах, тусгаарлагдаж буй газраас гарч болохгүй талаар байнга анхааруулна.

6.4.4. Сум, өрхийн эрүүл мэндийн төв нь гэрийн тусгаарлалтад байгаа ойрын болон хоёрдогч хавьтал болсон иргэнтэй өдөрт 2 удаа утсаар холбогдож, шинж тэмдэгийн тандалт хийж, тэмдэглэл хөтөлнө.

6.4.5. Эрүүл мэндийн талаарх мэдээллээ өгөхгүй байгаа иргэнийг утсаар тодруулж, утас нь холбогдох эсэхээс үл хамаарч нөхцөл байдлын мэдээг сум, хорооны цагдаагийн хэсэгт мэдэгдэнэ.

6.4.6. Эрүүл мэндийн байгууллага иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл, шинж тэмдгийн эмчилгээ, анхаарах асуудлын талаар хариу өгнө.

6.4.7. Гэрийн тусгаарлалтад байгаа ойрын хавьтлын “ПГУ” шинжилгээний анхны сорьцыг Нийслэлд ХӨСҮТ, аймагт тухайн шатны шуурхай хариу арга хэмжээний баг авах бөгөөд давтан шинжилгээг тухайн шатны эрүүл мэндийн байгууллага хариуцна.

6.4.8. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага нь гэрийн тусгаарлалтад байх хугацаанд шинж тэмдэг илэрсэн иргэнээс хугацаа харгалзахгүй “ПГУ” шинжилгээнд хамруулна.

6.4.9. Коронавируст халдварын “ПГУ” шинжилгээний хариу эерэг буюу батлагдсан тохиолдолд ХӨСҮТ-ийн шуурхай удирдлагын нэгж нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

6.4.10. Төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг шаардлагатай тохиолдолд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, харьяа аймаг, дүүргийн эмнэлгийн холбогдох мэргэшлийн эмчийг иргэнтэй холбон зөвлөгөө, мэдээлэл өгүүлнэ.

6.4.11. Нэн шаардлагатай тохиолдолд халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийг мөрдөн гэрээр үзлэг хийж, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

6.4.12. Гэрээр тусгаарлагдсан иргэнд эрүүл мэндийн хяналт хийж, зөвлөгөө, мэдээлэл өгч, шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулсан талаарх мэдээллийг харьяа Эрүүл мэндийн газарт 3 хоногт багтаан өгнө.

6.4.13. Гэрээр тусгаарлагдсан иргэн дэглэм, журам зөрчсөн тохиолдолд энэ талаар цагдаа, онцгой байдлын ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

6.5. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрх, үүрэг

6.5.1. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дуудлагыг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмчтэй холбон иргэнд утсаар зөвлөгөө өгөх боломжоор хангана.

6.5.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн дуудлагын дагуу аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмч тусгаарлагдсан иргэнээс асуумж, биеийн байдлын талаарх мэдээлэл авч, зөвлөгөө мэдээллийг утсаар өгнө.

6.5.3. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэнд тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тохиолдолд орон нутагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын тусгаарлан ажиглах хэсэгт хэвтүүлэн эмчилгээнд хамруулна.

6.5.4. Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд улсын хэмжээнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас телемедицинээр зөвлөгөө авах, баг дуудах шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажиглах хэсэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

6.5.5. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн дарга нар хамтран шийднэ.

6.5.6. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, холбогдох мэргэжлийн байгууллага, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг гүйцэтгэж, зөвлөмж тухайн гэр бүлд өгнө.

Долоо. Тагнуул, цагдаа, онцгой байдлын байгууллагын эрх, үүрэг

7.1. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэний “CLIX GPS” системээр иргэнийг хянах ажлыг хариуцаж, ухаалаг гар утасгүй болон “CLIX GPS” системийн хяналтаас гарсан хүний гэрийн хаягаар сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын баталсан хяналт тавих эрх бүхий ажилтантай хамтран хяналт тавина.

7.2. НЭМГ, орон нутагт аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, БОЭТ, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн шуурхай хариу арга хэмжээний багаас “Гэрийн тусгаарлалтын баталгааны хуудас”-ны зургийг цахимаар авч мэдээллийн сан үүсгэнэ.

7.3. Хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай штабт 10.00 цаг, 18.00 цаг, 24.00 цагт мэдээ өгч, тэмдэглэл хөтөлнө.

Найм. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрх, үүрэг

8.1. Тусгаарлагдсан асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй 0-18 насны эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай тохиолдолд түр хамгаалах байранд мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хариу үйлчилгээг 24 цагаар үзүүлнэ.

Ес. Хүмүүнлэгийн байгууллагын үүрэг

9.1. Гэрийн тусгаарлалтад байгаа тусламж үйлчилгээ шаардлагатай эмзэг бүлгийн өрхөд хоол хүнс бусад бараа материалын хангалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Арав. Сууц өмчлөгчдийн холбооны эрх, үүрэг

10.1. Байр орон сууцны цэвэрлэгээ, үйлчилгээнд хэрэглэгдэх угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжилтийн бодис, ажилтанд зориулан хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ.

10.2. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэний гаргасан хог хаягдлыг Сууц өмчлөгчдийн холбооны үйлчлэгч хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөж цуглуулан, зориулалтын хогийн цэгт хаяна.

10.3. Орон сууцны нийтийн эзэмшлийн зай талбайд чийгтэй цэвэрлэгээг өдөрт нэг удаа хийж, халдваргүйжүүлнэ.


10.4. Батлагдсан тохиолдлын хавьтал бүртгэгдсэн орон сууцны нэгдсэн хогийн цэгт хаясан хог хаягдлыг зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэн, тохижилт үйлчилгээний компанид дуудлага өгнө.

Арван нэг. Бусад

11.1. Ажил үүргийн хувьд олж мэдсэн хувь хүний нууцыг албан тушаалтан задруулах байх үүрэг хүлээнэ.

11.2. Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд “Эрүүгийн хууль”, “Гамшгаас хамгаалах тухай” хууль, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Гэр (амрах байр)-т тусгаарлан ажиглах
үйл ажиллагааг зохицуулах түр журмын
хавсралт



ГЭРИЙН ТУСГААРЛАЛТЫН БАТАЛГААНЫ ХУУДАС

Овог, нэр
Регистрийн дугаар.....
Утасны дугаар.....
Гэр (оршин суугаа)-ийн хаяг.....
Ажиглалтад байх хугацаа

Миний бие Улсын Онцгой комиссын даргын дугаар тушаалын батлагдсан “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 3 дахь хэсэгт заасны дагуу гэрийн тусгаарлалтад байхдаа дараах үүргийг дагаж мөрдөнө:

1. Хавьтлаар тооцогдож гэртээ тусгаарлагдах үед харьяалах эрүүл мэндийн байгууллага (өрх, сум, тосгон)-д мэдэгдэнэ.
2. Гэрээр тусгаарлагдаж буй хаяг, байршлаасаа гарахгүй, өөрчлөхгүй байхаа баталж байна.
3. Биеийн халуунаа өдөрт 2-оос доошгүй удаа хэмжиж, өөрийн эрүүл мэндийн байдлыг хянаж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн даруйд харьяалах өрх, сум, тосгоны эмчид утсаар мэдэгдэнэ.
4. Гэртээ агаар сэлгэлтийг 2 цаг тутамд, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийнэ.
5. Гэрийн тусгаарлалтад байх хугацаанд гэрээс гарахгүй, зочин урихгүй, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг эрсдэлд оруулахгүй байна.
6. Гар утсандаа “CLIX GPS” систем суулгаж, гар утсаа унтраалгүй биедээ ойр байлгаж, шуурхай штабаас ирсэн дуудлагад заавал хариулах, биеийн эрүүл мэндийн байдал болон байршлын талаарх мэдээллийг хяналт тавьж буй байгууллагад тухай бүр үнэн зөв мэдэгдэнэ.
7. Гэрээр ажиглах ажилд хяналт тавьж буй албан хаагчдын үйл ажиллагаанд саад учруулахгүй байх, гэрээр тусгаарлах дэглэм, журмыг зөрчихгүй байх үүрэг хүлээнэ.
8. Дүрэм, журам зөрчсөн нөхцөлд тусгаарлан ажиглах байр руу шилжиж, түүнтэй холбогдон гарах зардлыг нөхөн төлнө.

Дээрх үүргийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан дараах хариуцлага хүлээлгэхийг ойлгов.

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4. Иргэн халдварт өвчнийг бусдад зориуд халдаасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
2. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийг зөрчвөл хүнийг таван зуун нэгжтэй /1 нэгж 1000 төгрөг/ тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл

оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Эрүүгийн хуулийн 15.6 дугаар зүйл. 5.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин халдаах нөхцөлийг зориуд санаатайгаар зөрчиж, халдварт өвчин тархах нөхцөл бүрдүүлсэн, эсхүл бусдад халдаасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял эдлүүлнэ.

БАТАЛГАА ГАРГАСАН ИРГЭНИЙ НЭР, ГАРЫН ҮСЭГ..... /...../
БАТЛАН ДААСАН ИРГЭНИЙ НЭР, ГАРЫН ҮСЭГ/...../
РЕГИСТРИЙН ДУГААР:.....

МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨГӨӨ АВАХ 24 ЦАГИЙН АЖИЛЛАГААТАЙ УТАСНЫ ДУГААР:
.....

БАТАЛГАА АВСАН АЛБА ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛ,
НЭР, ГАРЫН ҮСЭГ..... /...../

2021 онысарын..... өдөр

Улсын онцгой комиссын даргын
2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
20 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19) ИЛЭРСЭН ОБЪЕКТЫГ ХАМГААЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/илэрсэн объектыг хамгаалах түр журам /цаашид "журам" гэх/-аар коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлын байр, орц, орон сууц, гудамж талбай, хашаа, албан байгууллага, нийтийн байр зэрэг объектыг хамгаалалтад авах үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Хамгаалалтыг зохион байгуулахдаа Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акт болон энэхүү түр журмыг мөрдлөг болгоно.

1.3. Объектыг хамгаалах гэдэг нь эрх бүхий эрүүл мэндийн байгууллагын саналыг үндэслэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол батлагдсан байр, орц, орон сууц, гудамж талбай, хашаа, албан байгууллага, нийтийн байр зэрэг объектыг халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор төрийн байгууллагын хяналт, хамгаалалтад авах үйл ажиллагааг хэлнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн байгууллагаас аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисст тухайн объектод коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг мэдээлнэ.

2.2. Голомтын өргөтгөсөн тандалт судалгаа хийхэд 24 цагаас дээш хугацаа шаардагдахаар бол тухайн нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын албан бичгээр ирүүлсэн саналын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн объектыг хамгаалалтад авах, цуцлах шийдвэрийг нэн даруй гаргана.

2.3. Шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын шуурхай штаб хариуцаж, хамгаалалтад байгаа объектын тухай мэдээллийг Улсын онцгой комиссын Шуурхай штабт нэн даруй хүргүүлнэ.

2.4. Шуурхай хариу арга хэмжээний багийн ахлагч голомтын тандалт судалгаа хийх үед цагдаагийн байгууллагын дэмжлэг шаардлагатай бол 24 цаг хүртэл хугацаанд объектыг хамгаалалтад авах хүсэлтийг харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад гаргаж гүйцэтгүүлнэ.

Гурав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын эрх, үүрэг

3.1. Тухайн объектыг хамгаалалтад авсан болон тусгаарлалтын талаархи мэдээлэл, зөвлөмжийг иргэдэд хүргэнэ.

3.2. Тухайн объектод байгаа айл өрхийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, халдваргүйжүүлэх бодисын нөөц, хангамж, эмзэг бүлгийн хүн амын судалгааг гаргаж,

хариу арга хэмжээ авна.

3.3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт (гадаад орчин цельсийн +10 хэмтэй үед) хийнэ.

3.4. Иргэнд шаардлагатай бараа бүтээгдэхүүний хангамжийг объектын дотор талд халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийн дор онцгой байдал, тухайн шатны Засаг дарга, СӨХ-тэй хамтран зохион байгуулна.

3.5. Нэн хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хангалт авсан иргэн нь тухайн хангалтын төлбөрийг төлнө.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын ойрын болон хоёрдогч хавьталд тухайн шатны эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний баг тандалт хийнэ.

4.2. Хамгаалалтад авсан объектод байгаа иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай үед эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ болон сэтгэл зүйн дэмжлэгийг шуурхай үзүүлж, эмчийн дүгнэлтийг үндэслэн лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллага руу зөөвөрлөнө.

4.3. Тухайн объектыг хамгаалалтад авсан бол цуцлах хүртэлх хугацаанд эрүүл мэндийн хяналтыг хариуцна.

4.4. Объектод коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын явсан зам мөрийн дагуу орсон айл өрх, үйлчлүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, хог хаягдлын цэгт голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /ЗӨСҮТ/, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг хийж гүйцэтгэнэ.

4.5. Хамгаалалтад авсан объектод байгаа иргэнээс "ПГУ" шинжилгээг нэн даруй авч, шинжилгээний хариуг Нийслэлд 24 цагийн дотор, орон нутагт боломжит бага хугацаанд гаргах бөгөөд хариуг үндэслэн хамгаалалтыг цуцлах саналыг албан тоот эсвэл цахимаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын шуурхай штабт хүргүүлнэ.

Тав. Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг

5.1. Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 45 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу коронавируст халдвар (КОВИД-19) илэрсэн голомт, объектын гадна орчинд хамгаалалтын бүс тогтоож, иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж, хэв журам сахиулна.

5.2. Нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор объектод нэвтрэх үед өрхийн эмч эсвэл мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хяналт дор хувийн хамгаалах хувцас хэрэгсэл (нэг удаагийн амны хаалт, бээлий, халат, нүдний шил, нүүрний хаалт, малгай, гутлын улавч)-ийг зааврын дагуу иж бүрэн өмсөж, тайлан зориулалтын уутанд хийж, аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмын дагуу устгуулна.

5.3. Хүндэтгэн үзэх шалтгаантай иргэнийг өөрийн хүсэлтийн дагуу хамгаалалтад авсан объект руу нэвтрүүлж болно.

5.4. Хамгаалалтад авсан объектын гадна орчинд тогтоосон бүсэд мэргэжлийн байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, шинжилгээ өгөхөөс татгалзсан иргэнд хуульд заасан арга хэрэгсэл /зайнаас хэрэглэх нэг бүрийн тусгай

хэрэгсэл/-ийг ашиглана.

5.5. Хамгаалалтын бүс рүү шуурхай алба, эмнэлэг болон тусгайлсан чиг үүрэг бүхий тээврийн хэрэгслийг саадгүй нэвтрүүлнэ.

5.6. Хамгаалалтад орсон иргэдийн санал, гомдлыг хүлээн авах утасны дугаарыг өрх бүрт мэдэгдэнэ.

5.7. Хамгаалалтад орсон иргэдээс ирүүлсэн санал, гомдол, тулгамдсан асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шуурхай зохион байгуулна.

Зургаа. Онцгой байдлын байгууллагын эрх, үүрэг

6.1. Хамгаалалтад авсан объект руу орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах, хэв журам сахиулахад цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

6.2. Хамгаалалтад авсан объектод байгаа өрхийн цахимаар өгсөн захиалгын /хоол, хүнс бусад зайлшгүй хэрэгцээт бараа/ түгээлтийг хүлээн авч иргэнд хүлээлгэн өгнө.

6.3. Объектын дотоод хүнс, эм, барааны түгээлтийг хороо, СӨХ-тэй хамтран халдварын сэргийлэлт хяналтын дэглэмийг баримтлан зохион байгуулна.

Долоо. Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын эрх, үүрэг

7.1. Хамгаалалтад авсан объект болон батлагдсан тохиолдлын явсан зам мөрийн дагуу голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх ажилд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

7.2. Ахуйн болон аюултай хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, устгалын байдалд хяналт тавина.

7.3. Тухайн тохиолдлын голомтоос шалтгаалан бусад иргэнд үйлчилгээ тасалдахгүй байх талаар эрүүл мэндийн байгууллагатай хамтран зөвлөмж гаргаж, мэргэжлийн байгууллагуудад чиглэл өгнө.

Найм. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын эрх, үүрэг

8.1. Хамгаалалтад авсан объектод асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй 0-18 насны эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүдэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай тохиолдолд түр хамгаалах байранд мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хариу үйлчилгээг 24 цагаар үзүүлнэ.

Ес. Хүмүүнлэгийн байгууллагын үүрэг

9.1. Хамгаалалтад авсан объектод байгаа тусламж үйлчилгээ шаардлагатай өрхөд хоол хүнс бусад бараа материалын хангалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Арав. Хамгаалалтад авсан объектын хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах ажиллагаа

10.1. Гэрийн нөхцөлд зайлшгүй шаардлагаар эмчилгээ хийлгэсэн тохиолдолд хэрэглэсэн тарианы ампул, зүү, тариур зэрэг хурц үзүүр, иртэй хог хаягдлыг аюулгүй хайрцагт (байхгүй тохиолдолд сүү, ундааны цаасан хайрцагт хийж, аюултай зүү тариур гэж бичих) цуглуулна.

10.2. Батлагдсан тохиолдлын гэрээс гарч буй хог хаягдлыг уутанд цуглуулж, эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний баг гадна талыг халдваргүйжүүлнэ.

10.3. Хамгаалалтад авсан объектод иргэдийн гаргаж тавьсан хог хаягдлыг Сууц өмчлөгчдийн холбооны үйлчлэгч хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөж цуглуулан, зориулалтын хогийн цэгт хогийг хаяна.

10.4. Энгийн хог хаягдлыг тохижилт үйлчилгээний компани тээвэрлэж устгана.

10.5. Хамгаалалтад авсан байрнаас гарсан аюултай болон ахуйн хог хаягдлыг нийслэлд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, орон нутагт тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад авна.

Арван нэг. Иргэний эрх, үүрэг

11.1. Иргэн нь аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, шуурхай штаб, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг мөрдөнө.


11.2. Иргэн нь объектын хамгаалалтыг цуцлах хүртэл халдвар сэргийлэлт, хяналтын дэглэмийг сахина.

11.3. Иргэн нь өөрт тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлагын талаар объектын хамгаалалт зохион байгуулж байгаа цагдаагийн байгууллагын ажилтанд мэдэгдэнэ.

Арван хоёр. Бусад

12.1. Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улсын онцгой комиссын даргын
2021 оны 20 дугаар сарын 25-ны өдрийн
20 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ГОЛОМТОТ БҮС НУТГААС АГААРЫН ХӨЛГӨӨР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ТҮР ЗААВАР

Нэг. Нислэгийн өмнө

1.1. Хилийн мэргэжлийн хяналтын албаны Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч нь нисэх бүрэлдэхүүний хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, тайлах, гарын ариун цэвэр сахих зэрэг халдвараас сэргийлэх сургалт хийнэ

1.2. Нисэх багийн гишүүд хувийн /биед тохиромжтой хувцас өмсөх, нислэгийн өмнө хоол, ундыг тохируулан хэрэглэх гэх мэт/ бэлтгэлийг хангана.

1.3. Нислэгийн явцад багийн гишүүдэд шаардагдах нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн багцад шингэнд тэсвэртэй комбинзон, нэг удаагийн малгай, шүүлтүүртэй амны хаалт /И95 хувиас дээш шүүлтүүртэй/, нэг удаагийн бээлий, нүдний шил эсвэл нүүрний хаалт, гутлын гадуурх улавч багцыг 3 ээлжээр тооцож хангана.

1.4. Нислэгийн явцад шаардагдах гар халдваргүйжүүлэх спиртэн суурьтай бодис, халуун хэмжигч, чагнуур, даралтын аппаратыг халдваргүйжүүлэхэд хэрэглэх 70 хувийн спирттэй хөвөн, гадаргууг халдваргүйжүүлэх 0.02 хувийн клорсепт, 0.015 хувийн жавелионы уусмал, автомакс, хог хаягдал цуглуулах шар өнгийн уут, цэвэрлэгээний хэрэгслийг бэлтгэнэ.

1.5. Зорчигчид хэрэглүүлэх нэг удаагийн амны хаалтыг нислэгийн явцад 2 цаг тутам солихоор тооцож бэлтгэнэ

1.6. Нислэгийн үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эм, тариа, эмнэлгийн хэрэгслээр хангана.

1.7. Ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгчийг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна.

1.8. Хог хаягдал цуглуулах шар уут бүхий хогийн савыг шаардлагатай цэгүүдэд хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулна

1.9. Зорчигчийн суудал бүрт нислэгийн үед баримтлах халдвар сэргийлэлт, хяналтын дэглэмийн тухай санамж, анхааруулга байрлуулсан байна.

1.10. Нисэх багийн гишүүд нислэгийн явцад хооллох тохиолдолд хоол, хүнсийг агаарын хөлгийн бүхээгт урьдчилан байрлуулсан байна.

1.11. Зорчигчийг агаарын хөлөгт оруулахын өмнө биеийн халууныг хэмжиж, "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийг бөглүүлэн гарыг халдваргүйжүүлж, амны хаалтыг сольж зүүлгэнэ.

1.12. Зорчигчийг агаарын хөлөгт 1-2 метр зайтай оруулах ба арын суудлын зорчигчдыг эхэлж суулгана. Эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг түрүүлж оруулж болно.

1.13. Нисэх бүрэлдэхүүн зорчигчдыг хүлээж авахаас өмнө хамгаалах хувцас

хэрэгслийг бүрэн өмссөн байна.

1.14. Нисэх бүрэлдэхүүн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан бол иж бүрэн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөхгүй байж болно.

1.15. Агаарын хөлгийн дарга, нисгэгч нь зорчигчид агаарын хөлөгт суухаас өмнө бүхээгт орсон байна.

Хоёр. Нислэгийн явцад

2.1. Бүхээгийн агаар сэлгэлтийг зорчигчийн заалны агаараас тусад нь хийнэ.

2.2. Нислэгийн явцад агаарын хөлгийн дарга, нисгэгч нь бүхээгийн хаалгыг нээхгүй, агаарын хөлгийн үйлчлэгч, томилогдсон албан хаагч, зорчигчтой шууд харьцахгүй, шаардлагатай тохиолдолд дотуур холбоогоор холбогдоно.

2.3. Зорчигчийг тасалбарт бичигдсэн суудалд суулгах, онцын шаардлагагүй бол босч явахгүй, суудал солихгүй, бусад зорчигчтой харьцахгүй, ярихгүй, эд зүйл солилцохгүй, хоол идэхээс бусад үед амны хаалтыг авахгүй байхыг дотуур холбоогоор анхааруулж, хяналт тавина.

2.4. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч нь агаарын хөлөг хөөрсний суудлын дараа тандалт хийнэ. /Зорчигчийн халууныг хэмжих, “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг бүрэн бөглөсөн эсэхэд хяналт тавих, “ПГУ” шинжилгээний хариуг тулгаж шалгах, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан эсэх, шинж тэмдэг илэрсэн тухай тэмдэглэсэн бол зовуурь, шалтгаан, аялалын маршрутыг тогтоож эрсдэлийг үнэлэх, суудлын дугаарыг тулгах зэрэг/

2.5. Зайнаас халуун хэмжихэд биеийн халуун 37.1 хэмээс дээш тохиолдолд 3 удаагийн давтамжтайгаар хэмжилт хийж, халуунтай нь тогтоогдвол шүүлтүүртэй амны хаалт /N95/-ыг зүүлгэж, бусад зорчигчоос тусгаарлана.

2.6. Халдварын сэжигтэй тохиолдлыг агаарын хөлгийн даргад дотуур холбоогоор мэдээлж, агаарын хөлгийн дарга нь Монгол Улсын агаарын хилийн зурваст ормогц Нислэг хөдөлгөөний үйлчилгээний албанд мэдээлнэ.

2.7. Цуглуулсан “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг шар өнгийн уутанд хийж, амыг битүүмжилнэ.

2.8. Зорчигчдын амны хаалтыг 2-3 цаг тутамд, бохирлогдсон тохиолдолд солиулах ба бохир амны хаалтыг суудлын урд байрлах цаасан уутанд хийж, шар өнгийн хогийн уутанд цуглуулна.

2.9. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч нь нисэх багийн гишүүдийн халдвараас сэргийлэх дэглэмийн хэрэгжидтэд хяналт тавина.

2.10. Зорчигчдод савласан ус, боосон хоол өгөх бол зорчигчийн суудалд урьдчилан тавьсан байна.

2.11. Зайлшгүй шаардлагаар зорчигчдод халуун уух зүйлээр үйлчлэхээр бол нэг удаагийн хэрэглээний аягийг ашиглан тавиур дээр байрлуулан өгнө. Гараас гарт өгөхийг хориглоно. Үйлчилгээ үзүүлсний дараа тавиурыг халдваргүйжүүлнэ.

2.12. Агаарын хөлгийн үйлчлэгч нь ариун цэврийн өрөөний суултуур, гар угаагуур, хаалганы гадна, дотно бариул бусад гар хүрэлцэхүйц гадаргууг 1 цаг тутамд автоматсаар шүршиж халдваргүйжүүлнэ.

2.13. Хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулан амыг сайтар битүүмжилнэ.

Гурав. Агаарын хөлөг газардсаны дараа

3.1. Агаарын хөлгийн дарга, нисгэгч нь зорчигчоос өмнө агаарын хөлгөөс буух ба завсрын /шар/ бүсэд хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж, гарыг халдваргүйжүүлсний дараа амны хаалт зүүж, халдваргүй бүсэд шилжинэ.

3.2. УОКШШ-аас ирүүлсэн нэрийн жагсаалтын дагуу хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалгаж зорчигчийг тусгаарлан ажиглалтад эрэмбэлэн цагдаагийн байгууллагын хяналтад шилжүүлнэ.

3.3. "Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг"-ийн хуудсыг үндэслэн зорчигчийг ангилан буулгана.

3.4. Зорчигчийг "сэжигтэй" "ойрын хавьтал", "эрүүл мэндийн шалтгаантай" /түүний асран хамгаалагч/, "бусад" гэсэн буулгана.

3.5. Зорчигчийн болон түүний ачаа, гар тээшийг тусгайлан бэлтгэсэн халдваргүйжүүлэх байранд халдваргүйжүүлнэ.

3.6. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд бусад зорчигчдоос түр тусгаарлан, холбогдох байгууллагад мэдээлж, тэмдэглэл үйлдэн эрүүл мэндийн байгууллагын шуурхай хариу арга хэмжээний багт, шилжүүлнэ.

3.7. Сэжигтэй зорчигчийн ойрын хавьтлыг тогтоож, бусад зорчигчоос тусад нь тээврийн хэрэгсэлд суулган, эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад шилжүүлнэ.

3.8. Ойрын хавьтлыг буулгасны дараа эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг хуваарилсан тээврийн хэрэгсэлд суулган, эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

3.9. УОКШШ-аас ирүүлсэн нэрийн жагсаалтын дагуу бусад зорчигчийг тусгаарлан ажиглах байранд хүргэх тээврийн хэрэгсэлд суулгана.

3.10. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсан иргэнийг тусгаарлахгүй.

3.11. Нисэх бүрэлдэхүүн халдвараас сэргийлэх дэглэмийг зөрчөөгүй тохиолдолд гэрийн тусгаарлалтад шилжүүлнэ.

3.12. Нисэх бүрэлдэхүүн халдвараас сэргийлэх дэглэмийг зөрчсөн тохиолдолд тусгаарлан ажиглах байранд өөрсдийг нь зардлаар тусгаарлана.

3.13. Сэжигтэй зорчигчийн мэдээг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын "Заавар батлах тухай" А/192 дугаар тушаалаар баталсан схем 3-ын дагуу шуурхай мэдээлж, хяналт шалгалтын нэгдсэн тайланг 8 цагийн дотор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газар болон холбогдох байгууллагад хүргүүлнэ.